



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар A/184

Хэрлэн сум

**Урьдчилан сэргийлэх ажилд
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайдын 2025 онд баталсан Объектын галын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хүрээнд иргэд, олон нийтийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах 2,334,650 (хоёр сая гурван зуун гучин дөрвөн мянга зургаан зуун тавин) төгрөгийг хавсралтаар баталсугай.

3. Иргэд, олон нийтийг объектын галын аюулаас урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцуулах, нэгдсэн арга хэмжээг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д нарт тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

04
 1/284

Аймгийн Засаг даргын 2025 оны
 дугаар сарын 04-ний өдрийн
 дугаар захирамжийн хавсралт



Шаардагдах тооцоо

д/д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Мөнгөн дүн
1	Шатахууны зардал	55 литр	193,600
2	Тараах материал	500 ширхэг	2,141,050
Нийт			2,334,650